

## **ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлаас 1996 онд “Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай” хуулийг батлан мөрдүүлж, академийн үйл ажиллагааг хууль, эрх зүйн хувьд зохицуулж ирсэн.

Тус хуулийг хэрэгжүүлж ирсэн хугацаанд бий болсон улс орны болон салбарын хөгжлийн бодлого, эрх зүйн шинэчлэл, дэлхийн улс орнуудын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан энэхүү хуульд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан судалгааг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн судалгааны багаар гүйцэтгүүлсэн. Судалгааны баг Шинжлэх ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, тайландаа тусгасан болно. Судалгааны ажлын тайланд тусгагдсан зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн Шинжлэх ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Шинжлэх ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хууль /1996/ нь 3 бүлэг 10 зүйл, 25 хэсэг, 62 заалттай бөгөөд хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслөөр 7 хэсэг, заалт нэмэгдэж, 10 хэсэг заалтад ямар нэгэн хэмжээгээр өөрчлөлт орсныг тооцвол тус хуулийн 27,4%-д нэмэлт, өөрчлөлт хийгдсэн болно.

Энэхүү хуулийн төсөлд зарчмын чанартай дараах өөрчлөлтүүдийг орууллаа.  
Үүнд:

**Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт,** Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлыг тодотгож улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр шинээр томъёолж, хуулийн төслийн холбогдох заалтуудад нэмж тусгаж өгөв. ШУА-ийн эрхзүйн байдлыг хэт ерөнхий, оновчтой бус тодорхойлсон хуулийн агуулгын хүрээг тэлж, Шинжлэх ухааны Академи нь судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх, нийгмийг соён гэгээрүүлэх, үндэсний соёл, хэл, түүх, угсаатны зүйн өв уламжлалыг судлах, хамгаалах зорилго бүхий шинжлэх ухааны төрийн төв байгууллага байхаар тодорхойлж өгсөн. Ийнхүү ШУА-ийн чиг үүрэг нэмэгдэж буйтай холбогдуулан академийн бүтцийн нэгжийг мөн энэ бүлэгт шинэчлэн тусгаж өгсөн болно.

**Хоёрдугаар бүлэгт,** Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шинжлэх ухааны академийн гишүүдэд академич хэргэм хүртээж буй зохицуулалтыг хуульчилж, мөн академийн чиг үүрэгтэй уялдуулан үндэсний түүх, хэл, соёл, угсаатны зүй, археологи, палеонтологийн эрдэм шинжилгээний музейг Академийн харьяанд ажиллуулж болох зохицуулалтыг нэмж тусгав.

ШУА-ийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор академийн удирдах дээд байгууллага, бүтцийн нэгжүүдийн чиг үүргийг тодотгож, удирдлагын бүрэн эрхийн хугацааг хуулийн төсөлд нэмж тусгав.

-- оОо ---